

БАТЛАВ:

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН

ЗАСАГ ДАРГА *Х.Баттулга* Х.БАТТУЛГА

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН 4, 5, 6 ДУГААР БАГИЙН
НУТАГ ДЭВСГЭРТ 2020 ОНД ЦАМХАГТ ГЭРЭЛ ХИЙХ ДААЛГАВАР

2020.06.19

1. Зураг төсөв зохиох үндэслэл: Баян-Уул сум ЗДТГазар. Сумын ОНХС
2. Захиалагч: Баян-Уул сум. ЗДТГазар
3. Барилга байгууламжийн нэр, байршил: Баян-Уул сум 4 дугаар багийн нутаг хуучнаар дэнжийн гуанзны баруун талд, 5 дугаар багийн нутаг, наадмын талбайгаас хойш явдаг авто замын баруун талд, 6 дугаар багийн төв талбайн хөшөөний урд талд, хашааны гадна тус тус шинээр хийх цамхагт гэрэл.
 1. Архитектур төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал: Тус сумын 3 багийн нутагт дахь дээрх газруудад гудамжны гэрэлтүүлэг дутмаг учир тав тухтай, орчны шаардлагад нийцсэн 6 тал руу тусгалтай хүчин чадал сайтай цамхагт гэрэлтүүлэг хийх шаардлагатай байна. Гэрлийн шон- 200мм-ээс багагүй диаметртай, 12 мм-с багагүй зузаантай , 11 метрээс богиногүй /гэрлийн шонгийн бодит өндөр 9 метрээс багагүй байх/ төмөр трубагаар хийж, цагаан өнгийн будгаар будна. /цамхагт гэрлийн шон нь өндөр хүчдэлийн зориулалттай төмөр бетон тулгуур байж болно/ Суурийг М250 марктай бетоноор цутгаж бэхжүүлнэ.
 2. Цамхагт хийц- нь 1,6 метрийн диаметртай 6 талтай байх бөгөөд төмөр хийцийг 32мм-ийн төмөр труба буюу түүнтэй дүйцэхүйц квадрат төмрөөр гагнаж угсрана. Төмөр хийцэд давхар 6 талтай бэхлэгч тогтоогч хийж өгөх бөгөөд гэрлийн үндсэн суурьтай холбож өгнө.

Цамхагийг шонд зориулалтын холбогч хомуаар бэхлэж өгнө. Цагаан өнгийн төмрийн зориулалттай будгаар будна.

3. Гэрэл- Гадна талбайн зориулалтын нэг бүр нь 250 ваттаас багагүй 6 ширхэг LED гэрэл байхаар төлөвлөгдсөн.
4. Гэрлийн утас- АБВГ 2x6 марктай гадна зориулалтын тэжээлийн утас байх бөгөөд, монтажны ил болон далд хэсгийг зориулалтын хуванцар хоолойгоор хамгаална. /Салаалагч болон холбогч хэрэгслүүд нь стандартын шаардлага хангасан байх/
5. Бусад- Гэрэлтүүлэг нь зориулалтын тэжээлийн хайрцагтай байх бөгөөд, автомат таслуур, тоолуур, соронзон болон цагийн зохицуулалт релейтэй байна. Цамхагт гэрлийн дээд үзүүрт нарны эрчим хүчээр тэжээгддэг аюулгүйн гэрлийг /анивчдаг улаан/ суулгах шаардлагатай.
6. Гүйцэтгэх хугацаа: 2020 оны 2-3 дугаар улиралд

БОЛОВСРУУЛСАН:

БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

/ Ш.ТӨМӨР-ИВЭЭЛТ

